

МАЯГТ ТМ-01а: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

Энэхүү ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн санал нь Төсвийн тухай хуулийн 33.2.5-д заасны дагуу ТЕЗ нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт болж Монгол Улсын 2024 оны төсвийн тухайн хуулийн нэгдүгээр хавсралт болж батлагдана.

Маягтыг дараах байдлаар бөглөнө:


- *Хөтөлбөрийн хүрэх үр дүн (2)*: Тухайн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн өөрчлөлтийг хэмжиж болохуйц үр дүн байдлаар бичнэ. Нэг хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн үр дүнд хүрэхээр тодорхойлж болно. Тодорхойлохдоо “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан холбогдох хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт, түүний суурь болон зорилтот түвшнийг харгалзан үзнэ. Хэрэв “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тухайн хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт тусгагдаагүй бол хөтөлбөрийг хариуцсан бодлогын мэргэжилтэн нь Эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны 12 сарын 28-ны өдөр А/167 тоот тушаалаар батлагдсан үр дүнд суурилсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулан хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн суурь ба зорилтот түвшнийг батлагдсан төсвийн хязгаарт багтаан тооцож, тодорхойлно. Ингэхдээ нэг хөтөлбөрт 3-с дээшгүй үр дүнг тодорхойлохыг анхаарна уу.
- *Үр дүнгийн шалгуур үзүүлэлт (4)*: Төсвийн хөтөлбөрийн үр дүн бүрийг хоёроос доошгүй, таваас ихгүй тоон эсвэл чанарын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.
- *Хэмжих зүйл (5)*: Шалгуур үзүүлэлтээр хэмжиж буй зүйлийн нэрийг бичнэ. Жишээ нь: “Архангай аймаг дахь жижиг дунд бизнес эрхлэгчдийн экспортын хэмжээг нэмэгдүүлэх” шалгуур үзүүлэлтийн хувьд хэмжигдэх зүйл нь “экспортын хэмжээ” юм.
- *Хэмжих нэгж (6)*: Тоо, хувь, түвшин, ширхэг гэх мэт хэмжих нэгжийг шивж оруулна. Жишээ нь, “хувь”.
- *Суурь*: Суурь түвшнийг хэмжсэн он болон тухайн үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг оруулна.
- *Зорилтот түвшин*: Тухайн онд хүрэх зорилтот түвшний утгыг оруулна.
- *Мэдээллийн эх сурвалж (12-13)*: Тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн утгыг баталгаажуулах албан ёсны статистик мэдээлэл, тайлан, маягт болон мэдээллийг боловсруулагч, хариуцагч байгууллагыг зааж өгнө.

А. Хөтөлбөрийн хүрэх үр дүнг дараах байдлаар тодорхойлно:

1. Салбарын эсвэл эрхлэх ажлын хүрээнд тулгарч байгаа асуудлыг шийдэх стратегийн зорилтыг агуулах, товч тодорхой, нэг утгыг илэрхийлэх;
2. Тодорхой шийдвэр гаргахад чухал мэдээллийг илэрхийлэх;
3. Гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч ажилтан, албан хаагч тус үзүүлэлтийг тодорхойлоход оролцсон байх, тэдний саналыг тусгах;

4. Зөвхөн ач холбогдолтой гол үр дүнг тодорхойлох (зөвхөн хэмжиж болох үзүүлэлтүүд, хийх ажил эсвэл процессыг тоочихгүй байх);

Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тодорхойлолт нь (i) хаана хэрэгжих (байршил), (ii) өөрчлөлтийг хэн хүртэх (үр шим хүртэгч, оролцогч тал), (iii) юуг өөрчлөхөөр зорьж байгааг, (iv) хүлээгдэж буй өөрчлөлтийн чиглэл (нэмэгдүүлэх/бууруулах) орсон үйл үгийн өнгөрсөн цагт бичсэн нэг өгүүлбэр байна (Зураг 1-ийг үзнэ үү).



Зураг 1. Хөтөлбөрийн хүрэх үр дүн тодорхойлсон өгүүлбэрийн бүтэц

Б. Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлно:

Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь тодорхой (**S**), хэмжигдэхүйц (**M**), биелэхүйц (**A**), ач холбогдолтой (**R**) бөгөөд хэрэгжүүлэх цаг хугацааг тодорхой тусгасан (**T**) буюу **SMART** шинж чанарыг агуулсан байна (Хүснэгт 2).

Хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлсон өгүүлбэрээс шалгуур үзүүлэлт нь тодорхой (S), хэмжигдэхүйц (M) болон цаг хугацаатай (T) байх шинж чанарыг шууд харах боломжтой бол, суурь болон зорилтот түвшнийг тодорхойлсноор биелэхүйц (A) байх шинж чанарыг тус тус харах боломжтой. Тулгамдаж буй асуудлын шийдлийг дэвшүүлснээр ач холбогдолтой (R) эсэхийг тухайн хэрэгжүүлэгч өөрөө үнэлнэ.

Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь (i) гол үзүүлэлт, (ii) юуг хэмжих, (iii) ямар нэгжээр хэмжихийг илэрхийлэн бичих бөгөөд, суурь он, түвшин бол зорилтот түвшний мэдээллийг баталгаажуулах мэдээллийн эх сурвалжийг зааж өгнө (Хүснэгт 1-ийг үзнэ үү).

Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих зүйл	Хэмжих нэгж	Суурь		Зорилтот түвшин			Мэдээллийн эх сурвалж
			Он	Түвшин	2023	2024	2025	
Архангай аймаг дахь жижиг дунд бизнес эрхлэгчид	экспортын хэмжээ	хувь	2021	25	35	45	50	Эдийн засгийн хөгжилд жижиг, дунд үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр тайлан.
Архангай аймаг дахь эмэгтэй бизнес эрхлэгч аж ахуйн нэгж	экспортын хэмжээ	хувь	2021	15	20	30	40	Эдийн засгийн хөгжилд жижиг, дунд үйлдвэрлэлийн оруулж буй хувь нэмэр тайлан.

Хүснэгт 1. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт

Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлсон эсэхийг шалгахдаа Хүснэгт 1 дэх асуултад бүгдэд нь “Тийм” гэж хариулагддаг болох хүртэл үргэлжлүүлэн сайжруулсаар байна.

Товчлол	Англиар	Шинж чанар	Шалгах асуулт	Хариулт
S	Specific	Тодорхой	Үр дүнг шууд илэрхийлж байна уу?	-
M	Measurable	Хэмжигдэхүйц	Үр дүнд хүрсэн эсэхийг яаж мэдэх вэ?	-
A	Attainable	Биелэхүйц	Хэмжих зүйлийг үнэн зөв тодорхойлсон уу?	-
R	Relevant	Ач холбогдолтой	Холбогдох үзүүлэлтийг сонгоход мэргэжилтнүүдийн санал, судалгаатай сонгосон уу?	-
T	Time-bound	Цаг хугацаатай	Үзүүлэлтэд хамааралтай мэдээллийг цуглуулах хугацаа болон авах давтамж тусгагдсан уу?	-

Хүснэгт 2. Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт шалгах асуулт

“Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх”, “Хуулийн хугацаанд хийх” зэрэг нь хүрэх үр дүнг тодорхой илэрхийлэхгүй тул хүрэх үр дүнг тодорхой, хэмжигдэхүйц болгож дараах байдлаар бичиж болно. Жишээ нь: “Төлөвлөгөөнд тусгасан **улирал тутам гаргах тайланг** бүх газар, нэгжид **дараа сарын 10-ны дотор** нь хүргүүлсэн байна”.

---oO---